

ДеФакто **ТОЙМ**

➤ РЕФЕРЕНДУМ ХИЙХ
НЬ ЗӨВ ҮҮ?

➤ ГААЛИЙН БАЙЦААГЧДЫН
АВЛИГЫГ ИЛЧИЛЛЭЭ

➤ ХАМТАРСАН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САН
БАЙГУУЛЖЭЭ

VI НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

НУУЦ, ХУДАЛ, ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙН ГАЙ

II НҮҮРТ

СҮЙРЭЛ ТОЛГОЙД ЭХЭЛДЭГ

IV НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.09.19, №11 (115)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

НУУЦ, ХУДАЛ, ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙН ГАЙ

Иргэдийн мэдээлэл авах эрх бол төрийн ажилтнууд эрх мэдлээ хувьдаа ашиглан авлига авах, ардчиллыг нураах аливаа оролдлогоос сэргийлэхэд чухал үүрэгтэй. Монголчуудад энэ эрхээ хэрэгжүүлэх боломж бага, төрийн байгууллагууд, ялангуяа төрийн өмчит хуулийн этгээдийн мэдээлэл ил тод бус, нууцлаг хэвээр байна. Мөн эдүгээ худал болон хуурамч мэдээлэл улам бүр олширч, сонгуулийн үр дүнд хүртэл нөлөөлөх оролдлого гарч байна. Монгол улсын төр засаг иргэдийнхээ мэдээлэл авах эрхийг нь хангаж, иргэд нь худал болон хуурамч мэдээллийг ялган салгаж чадахгүй байна.

НУУЦ МЭДЭЭЛЭЛ

2011 онд батлагдсан мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар монголд төр ба төрийн өмчит хуулийн этгээд нь иргэдийг ил тод нээлттэй мэдээллээр хангах үүрэгтэй. Гэвч энэ хуулийг батлахдаа холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулаагүйн улмаас хуулиуд хоорондоо зөрчилдөж, төрийн байгууллагууд, ажилтнууд нь тэдгээрийг ашиглан нээлттэй байх ёстой маш олон мэдээллийг нууцалсаар байна.

Энэ талаар *“Глоб Интернэшнл”* ТББ-аас “Олон улсын хэм хэмжээнд нийцсэн хуулиар дамжуулан олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг дэмжих нь” төсөл хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд кэйс судалгаа болон “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй тогтоомжийн дүн шинжилгээ” хийжээ. Энэ кэйс судалгааны хүрээнд төрийн нэр бүхий 16 байгууллагад тодорхой мэдээлэл авах хүсэлт гаргажээ. Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хүсэлтэд ямар ч хариу өгөөгүй аж. Мөн манай улсад мэдээлэлтэй байх эрхийг улам бүр хязгаарлаж буй нь тогтоогдов.



Төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 1995-2004 оны хооронд 22 байсан бол 2019 онд 595 болжээ.

Монголд мэдээллийг нууцлаад зогсохгүй, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан байгууллага ч байхгүй тул, иргэд ийнхүү эрхээ эдлэж чаддаггүй ажээ. Мэдээлэл улам бүр нууцлагдах болсон нь МУ-д авлига, шударга бус өрсөлдөөн газар авч буйн суурь шалтгаан. ▶▶

► ХУДАЛ БОЛОН ХУУРАМЧ МЭДЭЭЛЭЛ

МУ-д иргэд мэдээлэл авах эрхээ бүрэн эдлэж чадахгүй, төрийн мэдээлэл нууц хэвээр байгаатай зэрэгцээд олдсон мэдээлэл нь худал, эсвэл хуурамч байх нь элбэг болж байна. Нийгмийн мэдээллийн сүлжээ, зарим мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллийг бодитой, батлах баримттай эсэхийг иргэд ялгаж мэдэхгүй эсвэл шалгаж чадахгүй байна. Худал мэдээллийг (misinformation) давтан цацах нь иргэдийг түүнд итгэхэд хүргэж, улмаар нийгмийг төөрөлдүүлж байна.

Мөн зорилготойгоор тараасан хуурамч мэдээлэл (disinformation) нь үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хүний эрхийг хамгаалах зэрэг ардчиллын үнэт зүйлийг сулруулж, нийгмийг талцан хуваагдахад хүргэж байна. Хуурамч мэдээлэл нь ардчилсан сонгуульд нөлөөлж, иргэдийн чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах, нэр дэвшигчид болон төрийн байгууллагад итгэх итгэлийг нь бууруулж, улмаар ардчиллыг сулруулдаг.

Зарим улс орнууд нийгэмд хүчтэй тарж байгаа худал болон хуурамч мэдээлэлтэй тэмцэх талаар олон арга хэмжээ авч байгаа бөгөөд цаг хугацааны хувьд тэдгээрийг богино болон урт хугацааны гэж хоёр төрөлд хувааж болох юм.

Богино хугацааны шийдэл нь худал, хуурамч мэдээллийг тэр даруйд нь илрүүлж, худал, хуурамч болохыг нийгмийн болон уламжлалт мэдээллийн хэрэгслээр эргүүлэн шуурхай цацах явдал ажээ. Тэгэхийн тулд нийгмийн болон уламжлалт мэдээллийн хэрэгслээр цацаж буй мэдээллийг тогтмол ажиглаж, үнэн зөв эсэхийг шалгах (Social Media Monitoring) шаардлагатай. Энэ ажилд иргэний нийгмийн байгууллагууд өргөн оролцох үүрэгтэй.


Жишээ нь, монголд тоо баримтыг шалгадаг (fact checking) *“Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” (MCIR)* байна. Энэ төв нь аливаа мэдээллийг үнэн зөв эсэхийг шалгахад гадна худал мэдээллийг хэрхэн олж илрүүлэх талаар судалгаа хийж, сургалт зохион байгуулдаг. 9-р сараас эхлэн энэ төв Германы Дойче Велле Академитэй хамтран 'Fact Check Mongolia' хөтөлбөр эхлүүлж, сэтгүүлчдийн баримт нягтлах ур чадварыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Хөгжингүй улс орнуудад ашиглаж байгаа нийгмийн сүлжээг тандах арга хэрэгслүүд, холбогдох программ хангамжуудыг монголын хэвлэл мэдээллийнхэн түлхүү ашиглах шаардлага гараад байна.

Урт хугацааны шийдэл бол иргэдээ аливаа мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, мэдээлэл олж авах чадвартай болгох ажээ. Энэ нь мэдээлэлтэй харилцах суурь боловсролыг иргэддээ олгоно гэсэн үг юм. Жишээ нь, Швед улсад 2018 оноос эхлэн дунд сургуульд тусгай хичээл орж мэдээллийн үнэн, худлыг ялгах аргачлалыг зааж байна. Монголын дунд болон ахлах сургуульд аливаа мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, дүгнэх ур чадварыг заах шаардлагатай боллоо. Энэ талаар нийт иргэдэд ч бас онлайн, оффлайн хэлбэрээр суралцах боломжийг хангах цаг болсон. Монголд Глоб Интернэшнл ТББ 'Мэдээллийн эрин ба мэдээллийн бичиг үсгийн боловсрол' сэдвээр уулзалт зохион байгуулж иргэдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд оролцож байна. Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн боловсон хүчин бэлтгэх зорилгоор тодорхой хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.

Иргэд үнэн зөв мэдээлэлтэй байж л ардчиллын үйл явцад идэвхтэй оролцож, сайн засаглалыг бүрдүүлнэ. МУ-ын иргэд мэдээлэл олж авах эрхээ бүрэн эдэлдэг болохын тулд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах бие даасан байгууллагатай болох шаардлагатай байна. Холбогдох хуулиуд тэр дундаа нууцын тухай хуулиудын шинэчлэл үгүйлэгдэж байна. Харин хуурамч мэдээлэлтэй тэмцэхийн тулд мэдээлэлтэй харилцах суурь боловсролыг олгон, мэдээллийг тандаж, төрийн бус байгууллагуудаас нийгмийн мэдээллийн сүлжээг мониторинг хийх нь зөв шийдэл юм.

2019.09.18



The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

СҮЙРЭЛ ТОЛГОЙД ЭХЭЛДЭГ

Монгол улс зах зээлд дөнгөж шилжиж байсан 1990-ээд оны эхээр бидний хэдэн нөхөд Японы алдарт компаниудын түүх, түүний дотор “Киосера” компанийг үндэслэн байгуулагч Казуо Инаморигийн тухай уншиж, сонирхон судлаж байлаа. Түүний “Амжилтын дуршил” (Passion for success) нэртэй номыг олон дахин уншиж байсан бөгөөд нэг танил маань түүний KDDI компанитай хамтарч бизнес эхлүүлсэн билээ.

Казуо Инамори гуай 70 мянган ажиллагсадтай, 14 тэрбум ам.долларын эргэлтийн хөрөнгөтэй, нэг тэрбумын цэвэр орлоготой, 55 жилийн түүхэнд жил бүр ашигтай ажиллаж ирсэн алдарт “Киосера” (“Kyoto Ceramic”) компаниа 27 настайдаа байгуулж байжээ.

Мөн 23 жилийн өмнө түүний байгуулсан KDDI нь эдүгээ 15 мянган ажиллагсадтай, Японы харилцаа холбооны хоёр дахь том компани болсон төдийгүй өнгөрсөн жил гурван тэрбум ам.долларын цэвэр орлого олсон гэнэ.

Өөрийн менежментийн ухаан, өвөрмөц арга барил, нийгмийн төлөөх хүчин зүтгэлээрээ дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн, Японы алдарт бизнесмен Инамори гуайтай саяхан Киото хотод “Киосера” компанийн төв байранд тухлан ярилцсанаа гол санааг нэгтгэж уншигч та бүгдийн сонорт хүргэх нь цагаа олсон, тустай зүйл болох байх гэж үзлээ.

Инамори гуай одоо 83 настай ч, компанийнхаа хүндэт тэргүүлэгчээр ажиллаж, менежментийн арга барилынхаа талаарх лекцээ гадаад, дотоодод уншиж, сургалт явуулж байгаа ажээ.

Тэрээр гэргийн хамт 2006 онд монголд ирж Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд оролцож, хөдөөгүүр аялаж малчны гэрт зочилж, нүүдэлчин ахуй соёлтой танилцсанаа хуучлав. Чингис хааны тухай ном бичиж “Никкей” сонинд жилийн турш цувруулж гаргасан найз Сакайя Тайчи нь монголд очихыг зөвлөж, хамтдаа явсан аж.



JAL-ЫГ ДАМПУУРЛААС ГАРГАСАН НЬ

- Олон жил алдагдал хүлээж дампууралдаа тулаад байсан агаарын тээврийн JAL (Japan Airlines) компанийг та яаж ганцхан жилийн дотор ашигтай болгон эргүүлж чадав аа?

Миний найз, Тээврийн сайд JAL-ыг дахин сэргээхийг надад санал болгосон юм. Би агаарын тээврийн тухай ямар ч мэддэг, туршлагагүй тул эхэндээ шууд татгалзсан. Гэхдээ “Киосера”, KDDI хоёрыг бий болгож чадсан учир чи л үүнийг чадна гэсээр байгаад эцэст нь би зөвшөөрсөн юм.

Дампуурсан компанийг дотроос нь ажиглавал ажилчдынх нь оюун санаа, сэтгэл зориг нь “дампуурчихсан” байдаг. Сүйрэл толгойдэхэдэг. JAL ч тийм байсан. Ажлаа аваад бүх газраар нь явж, олон хүнтэй уулзахад ажиллагсад, нисгэгч, хөлгийн үйлчлэгчид бүгд л ном зааврын дагуу ажиллаж байсан болохоос хэн нь ч сэтгэлээсээ үйлчлэхгүй байсан. Заримдаа бүр ихэмсэг санагддаг байлаа.

Аливаа компани бүхлээрээ, дээрээсээ доошоо бүх ажиллагсад нь нэг үзэл бодолтой

байж, компанийг зөвхөн түүн дээр суурилж удирдах ёстой гэж би үздэг. Энэ нь ямар ч салбарын, ямар ч компанид адилхан.

Олон өдөр хэлэлцэж ярилцсаны эцэст бид JAL-ын менежментийн зорилгыг ажилтан бүрээ бие, сэтгэлийн хувьд аз жаргалтай байлгах гэж томьёолсон. “JAL бол та бүхний компани, бидний зорилго хүн бүр аз жаргалтай байх” гэж чин зорилгоо тодорхойлов. Барууны компаниуд шиг хувьцаа эзэмшигчдийн, эсвэл дээд удирдлагын ашиг сонирхлын төлөө гэж хэлээгүй. Энэ үзэл санааг бүх түвшинд шингээн, хүн бүр хичээн зүтгэсний үр дүнд JAL компани жилийн дараа

АМЖИЛТЫН ГУРВАН ГОЛ ЗАРЧИМ

- Инамори гуай, менежментийн тухай таны бичсэн номыг монголчууд бид ч амтархан уншдаг. Таны саяхан хэвлүүлсэн “Амьдрах зам” номыг л гэхэд Японд 1.5, Хятадад хоёр саяыг борлуулжээ. Би бас таны “Амёб удирдлага” гэдэг номыг саяхан уншлаа. Бүгд л олон чухал, сайхан санаа, шийдлийг дэвшүүлсэн байдаг. Та монголчуудад хандан амжилтад хүрэхэд хамгийн чухал гэсэн гурван зарчмыг хэлнэ үү?

Нэгдүгээрт, хүнийг хүндэл. Өнөөгийн ертөнцөд баян, ядуугийн ялгаа улам тэлсээр байна. Хөрөнгө баялаг бол хүний шуналын үр дагавар. Шунал хөгжлийг бий болгодог ч тогтолцооны гажгаас хамаараад газар сайгүй нийгмийн нэг хэсэг нь ядуу хэвээрээ үлдэж байна.

Авьяас чадвартай нь бий болгосон хөрөнгөө бусдын төлөө зарахгүйгээр энэ ертөнцөв найртай амьдрахгүй. Гарц нь юу вэ гэвэл бизнесийн хүмүүс бусдыгаа бүр илүү бодох, хайрлах явдал юм. Тэрээр надад нэг номоо дурсгахдаа эхний хуудасны дотор талд “Тэнгэрийг хүндэл, хүнийг хайрла” гэж ханз үсгээр доошоо татлан бичиж өглөө. Энэ нь бас “Киосера” компанийн уриа аж.

Хоёрдугаарт, даруухан бай. Их хөрөнгө, албан тушаал нь хүний ёс суртахууныг гажуудуулах, ихэрхэх, эсвэл ивээн тэтгэгчийн өнгө аясаар хандахад хүргэдэг нигууртай. Ийм манлайлагчтай компани, байгууллага түр зуурын амжилт гаргадаг ч, урт настай байдаггүй. Багийн гишүүд нь аажмаар унтарсаар, хамтарч ажиллахаа ч больдог.

184 тэрбум иений (бараг хоёр тэрбум ам.доллар) ашигтай ажилласан.

Өөрийн туршлагаас үндэслэн гаргасан Инамори гуайн менежментийн энэ аргыг амёб (нэг эстэй, тогтоол устай нуур цөөрөмд оршдог эгэл биетэн) удирдлага гэдэг бөгөөд ямар ч том компани, байгууллагыг жижиглэн хуваагаад, нэгж бүрийн даргыг томилж, аж ахуйн бүртгэл тооцоотой ажиллуулахыг ийн хэлдэг аж. Амёбын дарга дээд удирдлагатайгаа зөвшилцөөд тус тусын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлдэг.

Японд “Та байгаа учир би оршиж байна” гэж зүйр үг хүртэл бий. Бид өөрсдийгөө том юмны жижиг хэсэг гэж бодож байж л эв нийцтэй амьдарч, хамтарч чадна. Бусдыг эхлээд бод, өөрийгөө хажуу тийш тавьж сур. Бүх юмыг хоёр талаас нь харж бай.

Гуравдугаарт, зоригтой бай. Аливаа асуудлыг сайн бодож, олон талаас нь харж байж шийдвэр гарга. Бүх зүйлд нарийн мэдрэмжтэй хандаж, хийх ёстой л гэж үзвэл зоригтой шийд. Нэгэнт шийдсэн бол бүх хүч чадлаараа ажилла, дуустал нь яв. Тэгж чадвал хамт олон тань урам зоригтой ажиллаж, таны болон хамт олны чинь бүтээмж өндөр байна.

Инамори гуай JAL-д очихоор шийдсэний дараа долоо хоногт зөвхөн гурван өдөрт нь ажиллах тул цалин авахгүй гэжээ. Тэрээр хэдэн сая долларын үнэ цэнийг бүтээсэн ч сард 100 иений цалин авч байсан гэнэ. Киотод гэр бүл нь байсан бөгөөд өөрөө Токиод зочид буудалд ганцаараа амьдарч, ажиллаж байжээ. Өдөржин ажлаа хийж олон хүнтэй уулздаг байсан бөгөөд шөнө тарах үед нь бүх хоолны газар хаагдсан байдаг тул шөнийн дэлгүүрээс гоймон авч буцалсан усаар шингэлж идээд олон оройг өнгөрүүлж байсан гэдэг. 80 гарсан ч “Шийдсэн л бол шийдсэн гэж бодож байсан” гэнэ.

Нээрээ л, тэнгэрийг хүндэлж, хүнийг хайрлаж явцгаая, Монгол ах дүү нар минь!

2015.04.08



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.09.15-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

РЕФЕРЕНДУМ ХИЙХ НЬ ЗӨВ ҮҮ?

Улсын их хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг дуусч Ард нийтийн санал асуулга явуулах шийдвэрийг МАН-ын бүлэг гаргасан. Энэхүү шийдвэртэй зэрэгцээд МУ-ын Ерөнхийлөгч өргөн бариад байсан Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслөө татаж авсан. Улмаар Ард нийтийн санал асуулга явуулах тогтоолын төсөл өргөн барихдаа төрийн удирдлагын хэлбэрээ өөрчлөх эсэх асуудлыг асуулгад оруулах саналыг гаргаад байна.

Референдум хийх асуудал яг цаг хугацаагаа олсон гэж дүгнэж байгаа. МУ-ын түүхэнд 2 дахь удаагаа референдум явуулах гэж байна. Үндсэн хуулийг 1992 онд батлахад социалист нийгмээс чөлөөт эдийн засагт тулгуурласан ардчилал руу шилжихэд мэдээлэл,

мэдлэг хомс байсан. Одоо бол 27 жилийн туршлагаа эргэн хараад цаашдаа ямар Үндсэн хуультай байх дээр цэг тавих нь зайлшгүй.

Гол асуудал бол референдум хийх асуулгаа зөв тодорхойлох ёстой. 20 жилийн турш үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт хийгдсээр байгаад хагас парламентийн, хагас ерөнхийлөгчийн засаглалтай болчихсон. Энэ нөхцөл байдлаасаа салахын тулд асуулгад хариулах нь зүйтэй байгаа юм.

Гэхдээ үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай монголчуудын мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа шүү дээ. Иймээс манипуляци хийх зэрэг сөрөг асуудлууд гарч магадгүй.

ГААЛИЙН БАЙЦААГЧДЫН АВЛИГЫГ ИЛЧИЛЛЭЭ



Авлигатай тэмцэх газар сар тутам хэвлэлийн хурал хийдэг. Энэ сарын хурлын үеэр нэгэн бичлэг үзүүлэв. Энэ нь 2015-2016 онд үйлдэгдээд 2018 оны 1-р сард шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэрэг юм. Замын-Үүд дэх Гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч нар давтан үйлдлээр, бүлэглэж болон дангаар хахууль авсан, нэр бүхий иргэд, компанийн ажилтнууд хахууль өгсөн, шүүгдэгчдийн зарим өмгөөлөгчид нь худал мэдүүлэг өгөх гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн зэрэг 34 хүнд холбогдох хэрэг ажээ. Жишээ нь, Гаалийн улсын ахлах байцаагч нь бусадтай бүлэглэж, БНХАУ-аас импортоор оруулж буй 90 тонн олон нэр төрлийн

бараа гаальд худал мэдүүлсний улмаас улсын төсөвт төвлөрөх ёстой 28.281.063 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүйн хариуд нийт 4.500.000 төгрөгийн хахууль авсан нь тогтоогдож шүүхээс ял шийтгэсэн.

Сүүлийн 3 жилийн байдлаар АТГ-т гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой 52 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан, 42 эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэсэн байна.


Авлига авсан төрийн албан хаагчдыг зарлах нь зөв гэж харж байна. Гэхдээ зарлаж байгаа шалтгаан нь нээлттэй байх ёстой буюу хүмүүсийг жигшүүлэх зорилготой байх ёстой.

ХАМТАРСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН БАЙГУУЛЖЭЭ

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины айлчлалын үеэр 10 баримт бичигт гарын үсэг зурсан. Тэдгээрийн нэг нь Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК болон ОХУ-ын Шууд хөрөнгө оруулалтын сан хооронд хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан явдал байв. Энэ хэлэлцээрийн хүрээнд талууд рубль-төгрөгийн хамтарсан хөрөнгө оруулалтын санг байгуулж томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлснээр хоёр улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ОХУ-ын Шууд хөрөнгө оруулалтын сан нь 2011 онд ОХУ-ын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын санаачлагаар байгуулагдсан бөгөөд 40 орчим тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалтыг ОХУ-ын эдийн засагт татан төвлөрүүлж, нийт 1.5 их наяд рублийн хөрөнгө оруулалтын багцыг удирдаж буй томоохон хөрөнгө оруулалтын сан.

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК нь МУХБ-ны охин компани хэлбэрээр 2017 онд байгуулагдсан бөгөөд “Хөрөнгө оруулалтын сан” байгуулах замаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлэх зорилготой гэж байгаа. Тус компани эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг



нэмэгдүүлэх, үр ашиг бүхий томоохон төслийг санхүүжүүлэх зорилгоор “Үндэсний стратегийн хөрөнгө оруулалтын сан”-г 2018 онд үүсгэн байгуулж үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна. Мөн “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх зорилгынхоо хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 75.9 сая ам.долларын эх үүсвэрийн амлалтыг аваад байгаа юм байна.

МУ-ын хөгжлийг хувийн компаниуд л авч явна. Дэд бүтцийн төслүүдэд санхүүжилт их шаардлагатай байдаг учраас ЗГ өрийн дарамтыг өөр дээрээ авч хийдэг байсан. Харин одоо бол энэ ажлыг хувийн хэвшилд өгчих хэрэгтэй.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.

GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com

МИАТ ЦАХИМ СИСТЕМ

ОНЛАЙН БҮРТГЭЛ

Зорчигч та онлайнаар зорчигчын бүртгэлээ хийж, сүүх суудлаа сонгоорой. Ингэснээр та үнэт цагаа хэмнэх, өөрийн сүүх суудлаа урьдчилан захиалах боломжтой бөгөөд нисэх буудал дээр тээшээ өгөхдөө Тээшний бүртгэлийн **FAST BAG DROP** гэсэн тусгай цэгт тээшээ өгөхөд л хангалттай.

MIAT APPLICATION

Та хэзээ ч, хаанаас ч нислэгийн тийз захиалах, худалдан авах, нислэгийн төлөв, цагийн хуваарь болон нислэгийн мэдээлэл авах зэрэг олон төрлийн үйлчилгээг MIAT Application-с аваарай.

